МЭДЭЭ · 2021 оны 3-р сарын 12

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮДЭЭР ГАРЧ БАЙГАА ХЭРГҮҮДИЙГ ШУУРХАЙ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхий прокурор өнөөдөр /2021.03.12/ тушаал гаргаж, сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн хэргүүд болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагуудад шалгагдаж байгаа хууль, хяналтын байгууллагын нэр бүхий ажилтнуудтай холбоотой гомдол, мэдээлэл хэргийг хянаж, шуурхай шалгаж шийдвэрлүүлэх ажлын хэсгийг байгууллаа.

Ажлын хэсэгт дээрх хэрэг, гомдол, мэдээллийг хянаж, шуурхай шалгаж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч, танилцуулах, мөн гомдол, мэдээлэл гаргасан иргэдтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь хүлээн авахыг үүрэг болгожээ.

Дээрх хэргүүдтэй холбоотой гомдол, хүсэлтийг Улсын Ерөнхий прокурорын газрын өргөдөл, гомдол хүлээн авах алба болон 18001919 дугаарын утсаар хүлээн авах юм байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2809